



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА М.БАТГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 3/499

танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заалтыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрдуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал юм.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыгүнэлж цэгнэн, санхүүгийн тайланд ерөнхий бөгөөд зохистой толилуулгыг үнэлдэг.

Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн биржийн хооронд 2011 онд Хамтран ажиллах мастер гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Миллениум Ай Ти системийг 2012 онд бүрэн нэвтрүүлж ашиглалтанд оруулсан байна. Хамтран ажиллах мастер гэрээнд улсын төсвөөс нийт 14.2 сая ам долларыг тус системийг нэвтрүүлэхэд залцуулахаар тусгасан бөгөөд 2011 онд улсын төсвөөс 7,477,556.2 мянган төгрөгийн санхүүжилт өгсөнөөс хойш дахин санхүүжилт өгөөгүй байна. Хамтран ажиллах мастер гэрээний цаашдын санхүүжилт болон програмын ашиглалтын төлбөрийг нарийвчлан тооцох боломжгүй байна.

071222

Тайлангийн хугацаанд 1,793,960.0 мянгна төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцтгэлээр 965,741.0 мянган төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 46.2 хувиар тасалдуулсан байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол "Монголын хөрөнгийн бирж"ТӨХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХЗАЯА